

**ТУРКИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА***Б.Мандхай\**

Бүгд Найрамдах Турк Улс /БНТУ/-нь анх 1919 онд тусгаар тогтнолын дайн зарлан, 1923 оныг хүртэл “Османлы” улс гэгдэж байгаад 1923 оны 10 сарын 29-нд тусгаар тогтнолоо зарлан тунхаглаж, барууны чиг баримжаатай хөгжлийн чиг хандлагыг гадна үндэс болгосон Турк улсыг байгуулж, эдүгээ олон улсын харилцааны системд өөрийн гэсэн байр сууриа хэдийнээ эзэлж, бүс нутаг хоорондын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Газар зүйн байршлын хувьд Ази, Европ тивийн зааг дээр орших БНТУ нь 2007 оны байдлаар, 70 сая 586 мянга 256 хүн амтай, газар нутгийн хэмжээ 783,562км<sup>2</sup> талбайтай. Болгар, Грек, Гүрж, Армен, Азербайжан, Иран Ирак, Сири гэсэн 8 улстай хил залгаа, 3 талаараа Эгийн тэнгис, Хар тэнгис, Газар дундын тэнгисээр хүрээлэгдсэн, дэлхийн 1-р дайны дараа задран унасан Османы эзэнт гүрний суурин дээр байгуулагдсан үндсэн хуульт, парламентын засаглалтай, БН улс юм. Ази, Европ тивийн зааг дээр орших газар зүйн онцгой байрлалын улмаас Өрнө, Дорнын соёл аль аль нь дэлгэрсэн, Европын Холбоо /ЕХ/, Төв Ази, Ойрхи Дорнодын улс орнуудтай эдийн засаг, соёлын харилцаагаа идэвхижүүлж буй улс юм.

БНТУ эдийн засгийн хөгжлөөр дэлхийд 17 дугаарт бичигддэг. Өнөөгийн худалдааны эргэлт жилдээ 107 тэрбум долларын импорт, 170 тэрбумын экспорт хийдэг. Турк улс нь нийт 81 мужтай, муж болгон өөрийн гэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж гадаадад экспортолдог. Сүүлийн үед Туркийн экспорт асар их нэмэгдэж, эрчимтэй хөгжиж байгаагийн гол нууц нь Туркийн төр засаг, удирдлагууд дэлхийн хөгжилтэй бусад орнуудтай хөл нийлүүлэн алхаж, дэлхийн өнөөгийн эдийн засгийн эргэлттэй холбогдуулсан, шийдвэр гарган үйл ажиллагаагаа явуулж байгаатай холбоотой юм.

1980 оныг хүртэл Турк улсын эдийн засаг дотоод руугаа чиглэдэг байв. Өөрөөр хэлбэл, харьцангуй бусад оронд нээлттэй биш байжээ. 1980-аад оноос хойш эдийн засагтаа шинэчлэлт хийж хувийн хэвшил, чөлөөт эдийн засгаа эрчимтэй хөгжүүлж, экспортод чиглэсэн эдийн засгаа хөгжүүлж эхэлжээ. 1990-ээд оноос хойш Туркийн эдийн засаг эрчимтэй хөгжсөн гэж судлаачид үздэг. Үүнд нөлөөлсөн хүчин зүйл нь 1990-ээд онд Турк улс нь ЕХ-оос Гаалийн Орнуудын Холбоонд элссэн анхны улс юм. Энэ нь хил гаалиар ЕХ-той адилхан бараа бүтээгдэхүүнээ оруулж, гаргадаг гэсэн үг юм. Өнөөдрийн байдлаар, Турк улс ЕХ-нд

\* Б.Мандхай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

элсээгүй боловч эдийн засаг, улс төрийн хувьд Европ тивийн гишүүн гэгдэн, ЕХ-нд элсэхээр албан ёсоор нэрээ дэвшүүлээд байгаа юм. Туркийн эрчимтэй хөгжиж буй явц нь ЕХ болон дэлхийн бусад улсуудтай харилцах харьцаанд нэлээд давуу талыг олгож байна.

Турк улсын гадаадад нээлттэй бодлого нь тус орны хөгжлийн хоёр дахь зам байв. Турк улс, Төв Азийн Бүгд найрамдах улсуудтай, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан, найрсаг, сайн хөршийн харилцаа хөгжүүлэхийг гадаад бодлогынхоо үндсэн зорилтын нэг болгожээ. Тийм ч учраас эдгээр улсуудыг 1991 онд тусгаар тогтнолоо зарлахад нь анхлан хүлээн зөвшөөрч, улс төрийн харилцаа тогтоосон улсуудын нэг бол Турк улс юм.

Төв Азийн БН улсуудын хувьд, тусгаар тогтнол, бие даасан байдлаа дэлхий нийтэд таниулах, түүнчлэн барууны улс орнуудтай ойр дотно, идэвхитэй хамтын ажиллагаа өрнүүлэхэд ихээхэн түлхэц болж байсан улс бол Турк юм. Тэр ч утгаараа түүх, соёл, уламжлалын хувьд ижил төстэй зүйл ихтэй Турк улсын идэвхитэй хамтран ажиллах санаачлага, оролдлогыг талархан хүлээн авсан юм. Гэсэн ч Төв Ази судлаач эрдэмтдийн ихэнхи нь, Турк улсын Төв Азид чиглэсэн гадаад бодлого одоогийн түвшинд хэдэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээс хэтрэхгүй байгаа бөгөөд тус бүс нутагт өргөн хүрээг хамарсан, урт хугацааны стратегийн бодлого, төлөвлөгөө өдийг хүртэл байхгүй хэмээн шүүмжлэлтэй ханддаг болно. Бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй бусад улс орнуудын туршлагаас харахад, бүгд дээр дурдсан стратегийн төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагаар дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байгаа юм. Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг, Аюулгүй байдлын хамтарсан гэрээний байгууллага, Евро-Азийн эдийн засгийн нийгэмлэг, Төв Азийн хамтын ажиллагааны байгууллага, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага, Төв Ази, Япон, АНУ, Төв Азийн төсөл зэрэг олон улсын байгууллагууд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байна. Турк улсын тус бүс нутагт хэрэгжүүлж буй бодлогын үндэс нь зөвхөн бүс нутгийн тогтвортой байдал, аюулгүй байдал, бүрэн бүтэн байдлыг хангах төдийгүй, бүс нутагт аливаа гадны хүчин нөлөөгөө тогтоохоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдэж байна.

БНТУ-ын ЕХ-нд элсэхтэй холбоотойгоор, сүүлийн хэдэн жилд шийдэгдсэн чухал асуудлын нэг бол ЕХ-ны Комиссоос 2004 онд Турк улс, Копенгагений гэрээний шалгуур үзүүлэлтийг хангалттай биелүүлж чадсан хэмээн шийдвэр гаргасан. Энэхүү шийдвэр гарснаар ЕХ, Турк улсыг ЕХ-нд элсэхэд шаардагдах шаг дараалсан. арга хэмжээ, шинэчлэлийг хийж

эхлэх нь зүйтэй гэсэн санал, зөвлөгөө гаргасан юм. Энэхүү шийдвэрийн дагуу БНТУ-ын холбогдох шинэчлэлээ эхлүүлээд байгаа бөгөөд 2001, 2005 онд Үндсэн хуульд зарим өөрчлөлт оруулахаар баталжээ. Туркийн судлаачдын үздэгээр улс төрийн шинж чанартай эдгээр шинэчлэлийг хийснээр ардчилал, хүний эрхийн баталгааг илүү өргөн хүрээнд баталгаажуулсан “Чимээгүй хувьсгал” болж чаджээ.

БНТУ-ын ЕХ-нд элсэх үйл явцад голлох нөлөө үзүүлж буй бас нэгэн чухал шийдвэр ЕХ-ны улсуудын Засгийн газрын тэргүүн нараас бүрддэг Комиссын шийдвэр гарч 2005 оны сүүлээс эхлэн ЕХ-нд элсүүлэх хэлэлцээг эхлүүлсэн юм.

Европын Холбооны гишүүн зарим улстай харьцуулахад, БНТУ, ЕХ хоорондын харилцаа олон жилийн түүхтэй бөгөөд ЕХ-ны улсуудтай жилд дунджаар 75 тэрбум еврогийн худалдааны эргэлт хийдэг, үүгээрээ ЕХ-ны 5 дахь том худалдааны түнш болж чадсан байна.

2007-2013 онд хэрэгжүүлэх “ЕХ-ны стандартад нийцэхэд чиглэсэн багц хөтөлбөрийг боловсруулан 2007 оны 4 сарын 17-ний өдөр баталсан байна. Тус хөтөлбөрт нийгэм, эдийн засгийн салбарын шинэчлэлүүд, хамгийн чухал нь тус орны амьжиргааны түвшнийг ЕХ-ний орнуудын жишигт хүргэх асуудал тусгагджээ.

БН Турк улс бол Европ тив дэх ардчиллын үнэт зүйлсийн системийн салшгүй нэг хэсэг юм. ЕХ, цаашлаад тус тивд байрлах улс үндэстнүүдийн хооронд шашин соёлын харилцаанд БНТУ нөлөө бүхий улсын нэг юм.

Тухайлахад Кипр арал дээр аж төрдөг Турк иргэдийг хавчин гадуурхсан явдал 1964 онд гарснаас хойш Турк, Грек иргэдийн хооронд ширүүн зөрчил, мөргөлдөөн байнга гарах болсноор Киприйн асуудал анх үүссэн билээ. Турк, Грек иргэдийн хоорондын үндэстэн хоорондын тэмцлийн хор уршиг Турк иргэдэд хүндээр тусч байсан учир 1974 онд БН Турк улсын зэвсэгт хүчин Турк иргэдийн аюулгүй байдлыг хамгаалах, зорилгоор кипр арал руу цэргээ илгээсэн нь асуудлыг улам хурцатгаж, уг асуудал НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, Ерөнхий нарийн бичгийн дарга болон олон улсын харилцааны бусад томоохон субъектуудийн оролцоогүйгээр шийдэхэд хүнд болж ирсэн юм.

Сүүлийн жилүүдэд Киприйн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хийгдсэн томоохон алхмын нэг бол НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Кофи Аннаны санаачлан боловсруулсан төлөвлөгөө байсан бөгөөд тус төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр арлын 2 улсад ард нийтийн санал асуулга явуулж асуудлыг эцэслэх хамгийн боломжит шийдэлд хүрэхийг зорьсон юм.

Ард нийтийн санал асуулга 2004 оны 4 сарын 24-ний өдөр арлын 2 хэсэгт нэгэн зэрэг эхэлж асуулгын дүнгээр хүн амын 67% нь Туркийг дэмжиж, 76% нь Румийг эсэргүүцсэнээр төлөвлөгөө хэрэгжих үндэсгүй

болж арал дээр амьдрагч Рум үндэстнүүд 2004 оны 5 сарын 1-ээс ЕХ-ны гишүүн болсон юм. Киприйн асуудлыг НҮБ-ын оролцоогүйгээр шийдвэрлэх боломжгүй. Киприйн Рум тал зөвшилцөлд хүрэхээс үргэлж татгалзаж байгаагаас шалтгаалаад НҮБ-ын Ерөнхий Ассемблейн талуудын хооронд зөвшилцөл бий болгох оролдлого амжилтгүй болсоор байгаа хэдий ч арал дээрх туркууд болон БН Турк Улс Киприйн асуудлыг НҮБ-ын дэмжлэгтэйгээр 2 бүс бүхий, улс төрийн адил тэгш статустай болгоход чиглэсэн оролдлогыг байнга дэмждэг байна.

БН Турк улсын хувьд Ирак улс бүс нутгийн чухал нөлөөтэй улсын нэг юм. Туркийн газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах явдал Ирак улстай харилцах харилцааны үндсийг бүрдүүлдэг юм.

Сүүлийн 25 жилийн турш Ирак болон бүс нутгийн бусад улс орнуудад болсон зөрчил, мөргөлдөөнөөс үүдэн бий болсон хүмүүнлэг, эдийн засаг, аюулгүй байдлын асуудал нь Турк улсад байнга сөргөөр нөлөөлж ирсэн билээ. Турк улс, Иракийн нийт ард түмнийг улс төрийн үйл ажиллагааны идэвхитэй оролцоог нэмэгдүүлэх, шинэ үндсэн хууль боловсруулах, парламентын сонгуульд оролцохыг дэмжих зэрэг асуудалд голлох үүрэг гүйцэтгэж ирсэн билээ.

Турк улсын Засгийн газар, Иракт 50 сая доллартай тэнцэх тусламж үзүүлсний 20 орчим хувь нь Ирак улсыг шинээр бүтээн байгуулах үйл хэрэгт, үүнээс 5.4 сая долларыг хүмүүнлэгийн тусламжинд зарцуулсан байна.

2008 оны сүүлээр хийхээр төлөвлөж буй ард нийтийн санал асуулгыг явуулах нь төдийлөн оновчтой биш гэж Туркийн засгийн газар үздэг. Учир нь олон үндэстэн, соёлын эх өлгий болсон энэ улсын статусыг яаравчлан шийдвэрлэх нь Иракт бий болоод байгаа тогтворгүй байдлыг улам хурцатгах юм. Тиймээс тус улсад амьдрагч иргэд, үндэстнүүдийн хооронд харилцан ойлголцол бий болтол ард нийтийн санал асуулгыг хойшлуулах нь зүйтэй юм гэж олон улсын харилцааны томоохон субъектууд үзэж байгаа юм.

Монгол, Турк хоёр улсын хооронд дипломат харилцаа 1969 оны 6-р сарын 24-нд тогтсон боловч, дэлхийн улс төр, үзэл суртлын ялгаанаас болж, манай хоёр орны харилцаа 1990-ээд оныг хүртэл хөгжлийн тодорхой түвшинд хүрээгүй байжээ.

Монгол, Турк улс газар зүйн хувьд алс зайдуу оршдог боловч хэдэн мянган жилийн тэртээгээс түүх, соёлын хэлхээ холбоотой байсан төдийгүй нэгэн цагт нэг газар нутаг дээр оршдог байсан билээ.

Монгол Улсад ардчилал, өөрчлөлт шинчлэлийн үйл явц өрнөж, нээлттэй гадаад бодлого явуулах болсны үр дүнд, хоёр орны найрсаг харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх боломж нээгдэн, Монгол Улстай харилцах Туркийн сонирхол өссөн зэргээс тус хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд идэвхижин хөгжив. Манай хоёр

улсын эдийн засгийн харилцаа, холбооны хувьд газарзүйн байрлалаас шалтгаалан тээвэрийн зардал гэх мэт нилээд бэрхшээл учирдаг. Энэ нь манай хоёр улсын худалдаа, эдийн засагт бэрхшээл боловч 1990-д оноос хойш хоёр улсын эдийн засгийн харилцаа эрчимтэй хөгжиж байна.

Туркийн засгийн газрын урилгаар манай ГХ-ны сайд 1992 оны 5 дугаар сард Туркт албан ёсны айлчлал хийж “Найрамдал, хамтын ажиллагааны гэрээ”-г үзэглэж, “Худалдаа эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр”, “Боловсрол, шинжлэх ухаан, соёл, спортын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”, “Дипломат болон албан паспорттай иргэд харилцан визгүй зорчих тухай хэлэлцээр”, тэрчлэн цаашид байгуулбал зохих хэлэлцээр, протоколын талаарх тохиролцоонд тус тус гарын үсэг зурсан нь манай хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх зарим хууль зүйн гол үндэс суурийг тавьсанаараа чухал ач холбогдолтой болж үүнийхээ дагуу хэрэгжсээр байгаа билээ.

БНТУ манай улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Орхоны хөндийн хөшөө, дурсгалыг сэргээн засварлах, хамгаалах талаар санхүүгийн туслалцаа үзүүлэн хамтран ажиллах төсөл хэрэгжсээр байгаа билээ. Мөн хоёр улсын хооронд өнөөгийн байдлаар соёлын харилцаа хурдацтай хөгжиж, ялангуяа боловсролын тал дээр түлхүү анхаарч байгаагийн тод жишээ бол турк-монголын хамтарсан дунд сургууль 5 ажиллаж байгаа бол ТИКА байгууллагатай хамтарч МУИС-ийн ГХСС-д Турк судлалын танхим 2001 оноос эхлэн байгуулсан зэрэг болно. Үүнээс гадна Турк улс техник технологи, зам тээвэр аялал жуулчлал зэргийг манай улсад хэрэгжүүлэх зорилгоор олон салбарт хөрөнгө оруулж хамтран ажиллаж байгаа орон юм.

### **Ашигласан материал**

1. Гадаад харилцаа, 2004,
2. Гадаад харилцаа, 2005
3. “ГХЯ-ны 2004 оны үйл ажиллагааны тайлан” Гадаад харилцаа: Монгол улсын ГХЯ-ны мэдээллийн товхимол, УБ, 2005 он №8
4. “Avrasya bulteni” сэтгүүл
5. [www.mfa.gov.tr](http://www.mfa.gov.tr)
6. [www.cia.gov](http://www.cia.gov).
7. [http://www.diplomatikgozlem.com/haber\\_oku.asp?id=3389](http://www.diplomatikgozlem.com/haber_oku.asp?id=3389)
8. [www.tusam.org](http://www.tusam.org)
9. [tika.gov.tr](http://tika.gov.tr)
10. [www.diplomatikgozlem.com](http://www.diplomatikgozlem.com)
11. БНТУ-д суугаа ОББЭЭС Асим Арарын С1 TV-д өгсөн нэвтрүүлэгээс /2008. 09.12/